

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-9

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 5-7

2.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/ 7-9

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
05 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Сэддорж, Х.Баттулга, А.Ундраа;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Батсүмбэрэл, О.Цогтгэрэл.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт Б.Золбоо, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын мэргэжилтэн Б.Сансар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан тухай мэдэгдэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу санал хураалгах горимын санал гаргав.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Ч.Лодойсамбуу: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.18 дугаар зүйлийн гарчгийн “тоглоомын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “тоглоом зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.19 дүгээр зүйлийн “зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд” гэснийг “зохион байгуулахад” гэж, “ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн” гэснийг “ашиглуулсан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх
үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, А.Болортуяа, Байнгын хороодын ажлын
албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх
Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны яамны
Бодлогын газрын дэд захирал Д.Бямбадорж, Сангийн яамны Хөгжлийн
санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Батлан
хамгаалахын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Б.Эрхэмбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Зам, тээврийн яамны Бодлого
төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Эрчим хүчний яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн
нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ц.Эрдэнэбат, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын
дарга Д.Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын
газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн
бодлогын газрын ахлах мэргэжилтэн З.Райынбек, Эдийн засаг, хөгжлийн яамны
Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Г.Отгонцэцэг нар оролцов.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн
танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн
танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал
гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу санал
хураалгах горимын санал гаргав.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан
горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42
дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж

дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Ч.Лодойсамбуу: 1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.14 дэх “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих” төсөл арга хэмжээ нь мөн хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалтад байгаа төсөл арга хэмжээтэй агуулга, шалгуур үзүүлэлтийн хувьд давхцаж байгаа тул уг саналыг төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалттай нэгтгэж, Зорилтот түвшин “30” гэснийг “100” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “17,500.00” гэснийг “28,500.00” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 38 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Лодойсамбуу: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Эдийн засгийн байнгын хорооны ирц бүрдсэн тул хуралдаан эхэлж байна. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Энхбаярын Батшугар гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Мэндбаярын Мандхай гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Ринчиндоржийн Батболд гишүүн, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Бадрахын Найдалаа Саруулсайханы Цэнгүүн гишүүн, Отгоншарын Батнайрамдал гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Мөнхчулууны Энхцэцэг гишүүнээр ирснээр хуралдаан эхэлж байна.

Хуралдаан эхэлснийг мэдэгдье. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

2.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байгаа юу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2025 оны 5 дугаар сарын 23, 26-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулсан бөгөөд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын ахлах референт Сүрэнхорол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт Золбоо, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Батболд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга Лувсан-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Тайван, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Батзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал Гантулга, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Тэрбиш, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын мэргэжилтэн Сансар нар ирсэн байна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Хуулийн төслүүдийн эцсийн хувилбарыг бэлтгэх үед хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын төлөөлөл Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар найруулгын шинжтэй засвар хийж, нэр томъёог тодорхой болгох талаар хүсэлт гаргасан тул энэ дагуу төсөлд өөрчлөлт оруулах саналын томъёолол бэлтгэсэн байна.

Хуулийн төслүүдийн эцсийн хувилбарт өөрчлөлт оруулахад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн тохиолдолд зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулах дэгтэй байна.

Иймээс эхлээд горимын саналаар санал хураалт явуулах юм байна. Тэгэхээр гишүүд танхимдаа ирж санал хураалтад оролцохыг хүсье.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураахад бэлэн үү Лувсанжамц гишүүн? Дахиад хурууны хээгээ бүгдээрээ уншуулаад. Одоо хурууны хээгээ уншуулаад орно гэсэн үг төхөөрөмж рүүгээ. Орохгүй байна уу? Орсон.

Саналын томъёоллыг түрүүн уншсан. Санал хураалт шууд явах уу?

Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 76.5 хувиар дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн.

Одоо зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн дараах саналуудыг хураана.

Нэгт, Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.18 дугаар зүйлийн “гарчгийн тоглоомын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “тоглоом зохион байгуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан. Эдийн засгийн байнгын хороо санал хураалт

76.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.19 дүгээр зүйлийн “зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд” гэснийг “зохион байгуулахад” гэж, “ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн” гэснийг “ашиглуулсан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

70.6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал уншиж танилцуулна. Дараагийн асуудалдаа орёе.

14.53 цаг

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийн эцсийн хувилбарыг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна. Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцээд гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төслийн холбогдох хэсэг, заалт, дэд заалтад нэмж тусган төслийн

агуулга, зарчмыг алдагдуулахгүй бол төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж найруулгын шинжтэй засварыг хийж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Эрдэнэбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Бямбадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Батлан хамгаалахын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа Эрхэмбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Зам тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батбаяр, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Райынбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Отгонцэцэг нар ирсэн байна.

Тогтоолын төслийн эцсийн хувилбараас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын дахиад санал хураалт энэ гуравны хоёроор дэмжих ёстой учраас ирцэд орсон гишүүд нөгөө бэлдэх байдалдаа орж байна. Санал хураалтын бэлэн байдалд орж байгаа юм. Бүгдээрээ хуруугаа уншуулаад одоо санал хураана.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн гэж заасны дагуу дараах саналыг хураалгана.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нийт гишүүдийн 76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.14 дэх “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих” төсөл арга хэмжээ нь мөн хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалтад байгаа төсөл арга хэмжээтэй агуулга, шалгуур үзүүлэлтийн хувьд давхцаж байгаа тул уг саналыг төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалттай нэгтгэж, Зорилтот түвшин “30” гэснийг “100” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “17,500.00” гэснийг “28,500.00” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

14.58 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР